МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.27 № 43

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Зарим төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон үйлдвэрийн газрын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

"Эрдэнэс монгол" ХХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдмин" ХХК, "Эрдэнэт медикал эмнэлэг" ТӨХХК, "Монголросцветмет" ТӨҮГ, "Эрдэнэс оюу толгой" ТӨХХК, "Оюу толгой" ХХК, "Эрдэнэс силвер/алт ресурс" ТӨХХК, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХХК, "Гашуун сухайт автозам" ХХК, "Эрдэнэс үйлдвэрлэл, технологийн парк" ХХК, "Цемент шохой" ТӨХХК, "Хөтөл дулаан энержи" ТӨХХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, "Тавантолгой түлш" ХХК, "Багануур" ХК, "Шивээ овоо" ХК, "Мон атом" ТӨХХК, "Бадрах энержи" ХХК, "Гурван сайхан" ХХК, "Мон Чех ураниум" ХХК, "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК, "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК зэрэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын:

1. Сүүлийн 8 жилийн хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалт, санхүүжүүлсэн мөнгөн дүнгийн дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн зарцуулалтад хийсэн аудитын тайлангийн хамт;
2. Хуулийн этгээдийн өр төлбөрийн мэдээлэл, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн болон шүүхийн шатанд буй хэрэг, маргааны дэлгэрэнгүй мэдээлэл, шүүхийн шийдвэрийг тус тус сүүлийн 8 жилийн хугацаагаар;
3. Улсын төсөвт төвлөрүүлж буй мөнгөн дүн, 2025 онд Улсын төсөвт төвлөрүүлэн гүйцэтгэх орлогын даалгавар;
4. Ирэх онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд, санхүүжүүлэх мөнгөн дүн зэрэг дэлгэрэнгүй мэдээллүүд болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.МӨНХБАЯСГАЛАН

2024000069